



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 10 сарын 30 өдөр

Дугаар А/706

Булган сум

**Хүүхдийн эрхийг хангах, эрх нь зөрчигдөхөөс
урьдчилан сэргийлэх тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3 дахь хэсэг, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2, 16 дугаар зүйлийн 16.4.2, 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалт, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, 30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын хэмжээнд боловсролын салбарын үйлдвэрчний эвлэл, багш, ажилчид цалин хөлсөө нэмэгдүүлэх хөдөлгөөн өрнүүлж, хугацаатай болон хугацаагүй ажил хаялт зарлаж байгаатай холбогдуулан хүүхдийн аюулгүй байдлыг хангах, учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор холбогдох хууль, хамтын гэрээ, хөдөлмөрийн дотоод журамд нийцүүлэн сум, байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүйгээр 0-12 хүртэлх насны хүүхэдтэй эцэг, эх, асран хамгаалагчийн аль нэгийг цахимаар ажиллуулах эсхүл ажлын цагийг зохицуулах, хөдөлмөр эрхлэлтийн уян хатан нөхцөл хэрэглэх зэргээр дэмжлэг үзүүлж ажиллахыг сумын Засаг дарга, төрийн байгууллагын дарга, удирдлагуудад үүрэг болгосугай.

2. Тухайн суманд багш нарын ажил хаялт зохион байгуулах хугацаанд Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт суралцдаг эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн бүртгэл судалгааг гаргаж Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газарт хүргүүлэхийг сумын Засаг дарга, нарт, хүүхэд хамгааллын ажлыг эрчимжүүлэх, хүүхдийн эрхийг хангах талаар тодорхой арга хэмжээ зохион байгуулж ажиллахыг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар (Б. Оюунзаяа)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д. ПҮРЭВ-ОЧИР



6325010986